



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 558

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансад бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 69 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Хэрлэн сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон нийт 600,000,000.00 (зургаан зуун сая) төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө (конторын барилга)-ийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газрын балансад бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Нэргүй нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



000119/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
558.. дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Конторын барилга (Дорнод аймаг, Хэрлэн сум)	2018	м2	510	600,000,000.00
	Нийт дүн				600,000,000.00 (зургаан зуун сая)